

БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН
НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА

ЗӨВШӨӨРЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ
ХҮЛЭЭСЭН:

“М БИ СИ АЗИА ПАСИФИК” ХХК-ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.УРАНЧИМЭГ.....

Ц.ЭРДЭНЭБИЛЭГ.....



2025 ОНЫ ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ
РД: 5027292

ХЯНАСАН:

БОАЖА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН

ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН П.ШИНЭЦЭЦЭГ

ХЯНАСАН:

“М БИ СИ АЗИА ПАСИФИК” ХХК-ийн

ҮЙЛДВЭРИЙН ДАРГА Б.БОЛОРМАА

БОЛОВСРУУЛСАН:

“М БИ СИ АЗИА ПАСИФИК” ХХК-ийн

БАЙГАЛЬ ОРЧИН,ЭРҮҮЛ АХУЙ

ХАРИУЦСАН АЖИЛТАНБ.БУЯНХИШИГ

2025 он

АГУУЛГА

1.	М Би Си Азия Пасафик ХХК-н товч танилцуулга.....
1.1	Үйлдвэрийн хүчин чадал.....
1.2	Үйлдвэрийн барилга байгууламж.....
1.3	Техник тоног төхөөрөмж.....
1.4	Хяналт шинжилгээний лаборатори.....
1.5	Химийн бодисын агуулах.....
2	Төслийн талбай, түүний байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.....
3	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго.....
5	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....
6	Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлийн төлөвлөгөө.....
7	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....
8	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....
9	Хог хаягдалын менежментийн төлөвлөгөө.....
10	Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....
11	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....
12	Төлөвлөгөөний хэрэгжилтийг төрийн байгууллага болон оршин суугчид оролцогч талуудад тайлагнах зардал.....

М Би Си Азия Пасафик ХХК-н товч танилцуулга


Төслийн нэр:	“Шар айрагны үйлдвэр”-М Би Си Азия Пасифик төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“ М Би Си Азия Пасифик” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011587056
Регистрийн дугаар:	5027292
Холбоо барих дугаар:	76007770, 88043666, 99948200
Компанийн үйл ажиллагааны чиглэл:	- Шар айрагны үйлдвэр - Дотоод болон гадаад худалдаа
Төслийн байршил:	Улаанбаатархот БЗД,10 хороо, Амгалан/13260/ Гачууртын зам-102/1 50000м2 өөрийн эзэмшлийн талбай.
Төслийн ач холбогдол:	АПУ ХК-ийн охин компани болох М-Би-Си Азия Пасифик ХХК нь олон улсын брэнд болох “Tiger” шар айргийг анх импортлон нийлүүлдэг байсан бол 2007 онд жилдээ 300,000 гектолитр буюу 30,000,000 литр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай шар айргийн үйлдвэрийг ашиглалтад оруулсан. Ингэснээр “Tiger” шар айргийн брэндийг эх орондоо үйлдвэрлэж эхэлсэн юм. 2021 онд дэлхийн томоохон шар айраг үйлдвэрлэгчдийн нэг Heineken компанийн олон улсын Хүрэл стандартын болзлыг хангасан мөн 2024 оноос Heineken шар айргыг эх орондоо үйлдвэрлэж эхэлснээр технологи, чанар, бүтээмжийн өндөр гүйцэтгэлтэйг батлан харуулж байна. Үйл ажиллагаандаа ISO 22000 – Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо; ISO 9001 – Чанарын удирдлагын тогтолцоог бүрэн нэвтрүүлсэн. Чанартай, аюулгүй бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тогтолцоо бүхий анхны үйлдвэрлэлийн салбарын компанид тооцогддог. Тус компанид өнөөдрийн байдлаар Tiger, Сэнгүр,Боргио, Heineken үйлдвэрлэгдэж байна.
Үйлдвэрлэлийн хүчин чадал, тоног төхөөрөмж:	Германы Кронэс, Хупман фирмийн бүрэн автоматчлагдсан шугамтай.
	Үйлдвэрийн хүчин чадал жилд 300.000 гектолитр бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай. 15,000 ширхэг лаазтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай
Ажиллах хоног:	365 хоног
Ажиллах хүчин:	38 төрлийн ажлын байранд 155 ажилтантай
Уур,дулаан хангамж	Өөрсдийн уурын зуух
Цахилгаан хангамж:	“Амгалан” ТӨХК
Цэвэр усан хангамж:	Төвийн шугамд холбогдсон. УСУГ-тай гэрээгээр хамтран ажилладаг.
Хаягдал ус:	
Хөргөлтийн төхөөрөмж:	1x491 kW GEA Grasso 2x246 kW kW compressor
Аюултай хог хаягдал	Химийн аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй “Түмэн Эгшиг” ХХК-тай гэрээтэй.
Хог хаягдал:	Энгийн хаягдал-БЗД тохижилт үйлчилгээний газар, “Эко орчин” ХХК Дахивар хаягдал “Мультифак” “Баялаг фийд”болон бусад дахин боловсруулдаг компанитай гэрээтэй ажиллаж байна.

Үйлдвэрийн газарзүйн байрлал ба засаг, захиргааны харьяалал

Үйлдвэрийн байршил: “М Би Си Азия Пасифик” нь Улаанбаатар хотын БЗД 10-р хороонд байршилтай нийт 50000м2 талбай бүхий үйлдвэрлэл, аж ахуй, контор, агуулахын зориулалттай.



Зураг:1-1 “М Би Си Азиян Пасифик” байршил



Зураг 1-2 Газарзүйн байрлал

Тус нэгж талбар нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалтын Хангайн их мужийн өндөршлийн бүсийн Хэнтийн мужийн Хэнтийн захын тойрогт багтана. Гадаргын налуу нь зүүн хойноос урагшаа чиглэсэн 1-2 хэмийн налуутай 7-8 баллын газар чичэрхийллийн бүсэд багтана. Эзэмшил газрын орчимд дунд зэргийн зузаан хар хүрэн хөрс, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэйгээр тархаж байна.

Үйлдвэрлэлийн хүчин чадал

Герман улсын Krones-ийн төхөөрөмжөөр тоноглогдсон цагт 1500ш лаазтай бүтээгдэхүүн савлах хүчин чадалтай лаазны шугам, мөн тус бүр нь 100тн багтаамжтай 9 танк бүхий шинэ исгэлтийн цехийг 2010 онд ашиглалтанд оруулснаар үйлдвэрийн хүчин чадал 2 дахин буюу 30 сая литр болон нэмэгдсэн. Энэ нь бүтээгдэхүүний тоо, нэр төрлийг нэмэх боломжийг бүрдүүлж өгсөн. Герман улсын Krones-ийн төхөөрөмжөөр тоноглогдсон цагт 15000ш лаазтай бүтээгдэхүүн савлах хүчин чадалтай лаазны шугам, мөн тус бүр нь 100тн багтаамжтай 11 танк бүхий шинэ Исгэлтийн цехийг 2010 онд ашиглалтанд оруулснаар үйлдвэрийн хүчин чадал 2 дахин буюу 30 сая литр болон нэмэгдсэн. Энэ нь бүтээгдэхүүний тоо, нэр төрлийг нэмэх боломжийг бүрдүүлж өгсөн.

Сэнгүр брэндийхээ 2015 оноос төрлийг нэмж улаан буудайн шар айраг Сэнгүр вайт (Sengur white)-ыг худалдаанд гаргаж, 2016 онд нимбэг жимсний амттай Сэнгүр радлер (Sengur radler lemon), 2017 онд алим ба цангис жимсний амттай Сэнгүр радлер (Sengur radler apple, cranberry) шар айргийг тус тус зах зээлд нийлүүлэн, спиртийн агууламж багатай шар айраг хэрэглэгчид тэр дундаа эмэгтэй хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагыг ханган ажиллаж байна. Хамгийн отгон брэнд болох манго ба тоор жимсний амттай Сэнгүр радлер (Sengur radler mango, peach) шар айргийг 2019 оноос үйлдвэрлэж эхлээд байна.

2024 онд бид **Heineken брэндээ эх орондоо үйлдвэрлэн, ОУ-ын стандартыг бид хамтдаа амжилттай нэвтрүүлж чадлаа.** Бид брэндийн үнэ цэнийг хадгалан бүтээгдэхүүнийг чанарын өндөр түвшинд үйлдвэрлэн ажиллаж буй дэлхийн 71 улсын нэг боллоо.



Зураг 1-3 “М Би Си Азия Пасифик” үйлдвэрлэгддэг бүтээгдэхүүнүүд


Үйлдвэрлэлийн гол барилга байгууламжууд



Зураг 1-4 “М Би Си Азия Пасифик” үйлдвэрийн гадна зураг



Зураг 1-5 “М Би Си Азия Пасифик” үйлдвэрийн дотоод орчин нөхцөл байдал



Зураг 1-6 “М Би Си Азия Пасифик” үйлдвэрийн барилга байгууламжийн план зураг

Дотоод хяналтын лаборатори

Манай дотоод хяналтын лаборатори нь MNS17025 магадлан итгэмжлэлтэй мөн Heineken Lab star нэг одтой. Хими болон микробиологи, амталгааны лабораторитой бөгөөд түүхий эдээс эхлээд эцсийн бүтээгдэхүүн хүртэл бүх төрлийн шинжилгээг мэргэжлийн 5 чанарын шинжээчтэйгээр гүйцэтгэж байна. Heineken олон улсын харьцуулсан шинжилгээ болон ХАБҮЛЛ ур чадварын сорилтод тогтмол оролцож шалгуурыг тогтмол хангадаг.



Зураг 1-7 “М Би Си Азиан Пасифик” чанар лабораторийн хамт олон



Зураг: 1-8 физик химийн лаборатори



Зураг 1-9 Микробиологийн лаборатори



Зураг:1-10 Амталгааны лаборатори

Химийн бодисын агуулах

Химийн хортой болон аюултай бодис, нэгдлүүдийг хэрэглэх зориулалтаас хамааран лабораторийн болон агуулахын нөхцөлд хадгалдаг. Бүтээгдэхүүн үйлвэрлэлийн хяналт шинжилгээнд ашиглах химийн бодисуудыг лабораторид хадгалах бөгөөд исгэлт болон ус боловсруулах хэсэгт ашиглах химийн бодисууд, ариутгал цэвэрлэгээ хоргүйжүүлэх цэвэрлэгч бодис, нэгдлүүдийг химийн бодисын агуулахад хадгалж байна. Хадгалж байгаа бодисуудын ихэнх нь шингэн төлөвтэй хуванцар сав, баллонд 30-40кг-аар савлагдсан байна.

Химийн бодисын агуулах нь “Хөдөлмөр аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах” MNS6458:2014 стандартын шаардлагыг хангасан, агуулахын барилга нь галын дохиололын систем болон гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг MNS 5566:2005 стандартад заасны дагуу байрлуулсан. Үйлдвэрийн химийн бодисын агуулах нь лабораторын дүгнэлттэй, стандарт журмуудыг хангасан тэмдэг тэмдэглээтэй, хамгаалах хэрэгсэлтэй болно. Мөн төслийн хүрээнд ашиглагдах бодис тус бүр нь хор аюулын лавлах мэдээлэлтэй, бодисуудын ашиглалт, зарцуулалтыг хянадаг, мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан.



Зураг 1-11. Химийн бодисын агуулахын гадна болон дотоод нөхцөл

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Төсөл хэрэгжих талбайн газарзүйн онцлог

Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны урд үзүүр болох Баянзүрх, Богд хан, Сонгино хайрхан, Чингэлтэй хайрхан уулсаар зүүн, урд, баруун, хойд талаараа тус тус хүрээлэгдсэн бөгөөд Туул, Сэлбэ голуудын бэлчир хөндийд байрладаг. Дунджаар далайн түвшнээс дээш 1351м өндөрт оршдог. Нийт 4,704.4 м.кв нутагтай. УБ хот нь урдаас хойш 5км, зүүнээс баруун талруу ойролцоо 30км-ийн зайд зүүнээс баруун тийш тэлж тогтсон.

2.2 Төсөл хэрэгжих талбайн геологийн тогтоц

Судалгаанд хамрагдаж байгаа объект нь Улиастай голын баруун жигүүрт байрлах ба гидрогеологи-инженер геологийн нөхцөлийн хувьд дөрөвдөгчийн сэвсгэр хурдас бүхий голын II дэнжид байрлах бөгөөд урьд өмнө судалгааны ажлын хүрээнд өрөмдсөн гидрогеологи-инженер геологийн хайгуулын цооногуудын геологи-литологийн зүсэлтээс үзэхэд чигжээстэй бул чулуутай сайр хайрга бүхий хөрс чулуулаг нь (голын адаг орчимд) 35-42м зузаантай, элсэн чигжээстэй бул чулуутай сайр сайрган (голын дунд хэсэгт) хөрс чулуулаг нь 5-10м зузаантай, шавар чигжээстэй сайр сайрган хөрс нь (голын дунд хэсэгт) 15-20м зузаантай, харин үндсэн чулуу болох хувирмал чулуулаг (занар, гуранз) нь голын эхэн хэсэгт 20м-ээс, голын адаг хэсэгт 25-38м-ээс эхлэн доош үргэлжилнэ. Харин голын адаг орчимд үндсэн чулуулаг нь нилээд доороос (50-60м-ээс) ордог байна.

2.3 Уур амьсгал

Баянзүрх дүүрэг (БЗД) орчим жилийн агаарын дундаж температур -3.0°C , өвлийн хүйтэн агаарын дундаж температур 1 дүгээр сард $-20-25^{\circ}\text{C}$, зуны дулаан агаарын дундаж температур 7 дугаар сард $19.0-20.1^{\circ}\text{C}$ дулаан байдаг. Агаарын үнэмлэхүй бага температур -49°C (1954 оны 2-р сард) хүрч байсан бол, үнэмлэхүй их температур 39.5°C (2005 онд) хүрч температурын агууриг 87.6°C болдог. Өвөлдөө -30°C -аас доош хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим, зундаа 30°C -аас дээш дулаарах өдрийн тоо 10 орчим байна. 10°C -ээс давж дулаарах өдөр хавар 5 сараас намар 8 сарын 25 хүртэл 80 орчим хоног байдаг.

Салхины хурд бусад нутгаас бага, жилийн дунджаар 0.9-1.5м/сек байх боловч голын хөндий нутагт 2.5-4.8 м/сек хүртэл нэмэгддэг.

Жилийн дундаж харьцангуй чийгшил 70-75% хүрч хамгийн хуурай хаврын улиралд 45-55% байна. Энэ бүс нутагт хуурай өдөр 25-30 өдөр тохиолдож байхад 40-50 өдөр нь 70%-иас дээш чийгтэй. Хур тунадас жилдээ 250-300мм байдаг ба энэ нь жил бүр харилцан адилгүй байна (Г.Намхайжамцан) гэжээ. Хур тунадасны 95-97% нь дулааны улиралд, 75-80% нь зуны улиралд ордог ерөнхий зүй тогтолтой. Хэнтийн уулсаар унах хур тунадасны 80-85% нь зуны улиралд орох бөгөөд жилдээ 350-450 мм хур тунадас ордог байна.

2.4 Гадаргын болон газрын доорх ус

Тухайн бүс нутгийн шинж төрхтэй гидрогеологийн нөхцөлийг илэрхийлж буй газрын доорх усны тархалт, бүрэлдэн тогтолтын ерөнхий байдал болон геологийн тогтоцын өвөрмөц онцлогийг үндэслэн, судалгааны дэвсгэр талбайн хүрээнд гидрогеологийн давхарга зүйн хувьд дараах бие даасан уст үе давхарга, газрын доорх усны бусад хуримтлал, бөөгнөрлийг ялгаж байна. Үүнд:

1. Аллювийн гарал үүсэлтэй орчин үеийн сэвсгэр хурдасны зузаалаг дахь уст үе давхарга.
2. Доод-дунд девоны настай бялхмал-тунамал чулуулгийн массив дахь алаг цоог тархалттай газрын доорх ус.

Тус үйлдвэр Ус Сувгийн Удирдах Газар (УСУГ)-тай хийсэн “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах” гэрээний дагуу усны дээд эх үүсвэрээс хэрэглээний усаа хангадаг.

2.5 Хөрс

Төслийн талбайн Монгол орны хөрс-газарзүйн мужлалын хувьд Хангайн их мужийн өндрийн бүсшилтэй нутгийн Хэнтийн мужийн Хэнтийн захын тойрогт хамаарагдана.

Төслийн талбайг Хөрсний бүлгээр нь харахад тал газар, хөндий хотгорын хөрс, чийгт гарлын хөрсний зааг дээр оршиж байна.

Тус талбайн аллювийн нугын /аллювийн нугын давсархаг, хархүрэн/ сайр чулуурхаг хархүрэн, нугын цэвдэгт /нугат намгийн цэвдэгт, уулын хархүрэн/ уулын нимгэн харшороон, уулын хархүрэн/ уулын ойн ширэгт бараан бараан хөрсний ангилалд хамаарч байна.

Хөрсний хүнд металлын шинжилгээний үзүүлэлтийг хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (Стандарт MNS 5850:2008)-тэй харьцуулан харахад стандартаас даваагүй буюу стандарт хэмжээнд байна.

2.6 Амьтны аймаг

Нийслэл хотын ногоон бүсийн дэвсгэр нутаг нь амьтны аймгийн газарзүйн мужлалаар умардын их мужийн хөвч тайгын дэд мужийн Хэнтийн тойрогт багтана. Судлаачдын тооцоолсноор энэ нутагт 50 орчим зүйл хөхтөн амьтад тэмдэглэгджээ. Эдгээрээс буга, бор гөрөөс, зэрлэг гахай, хүдэр, янгир, зэрэг туурайтан амьтад, ногоон бүсийн шилмүүст болон холимог ойд амьдардаг. Харин ойн зах, хад асгат уулс, ам, хөндийгөөр чоно, үнэг, хярс зэрэг махан идэштэн, чандага, туулай, дагуур огодой зэрэг туулай хэлбэртэн амьдардаг. Түүнчлэн хуш голлосон шилмүүст ойд хэрэм, жирх, ойн хормойгоос эхлээд бүх ам хөндийгөөр тарвага, урт сүүлт зурам, огтоно, үхэр огодой зэрэг амьтад бүсийн хэмжээнд элбэг тархжээ. Жигүүртний хувьд энд нилээн олон буюу 103 зүйлийн шувуу тэмдэглэгдсэн бөгөөд уулын ар өврийн холимог ой, ам хөндийд хур сойр, ятуу шаазгай, бялзуухай, болжмор, хөх бух, хараацай, хөх цэцгий, хад цохиогоор хон хэрээ, харцага, бүргэд, начин шонхор зэрэг шувууд байна.

Төсөл хэрэгжих БЗД-ийн 10-р хороо нь хүн амын суурьшлын бүс тул шууд нөлөөлөлд өртөх нь нэн ховор, ховор ан амьтан байхгүй.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Тус төслийн бүх үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлохдоо БОНХЯ-ны 2014 оны 04-р сарын 10-ны өдрийн А117 тоот тушаалаар батлагдсан аргачлалд тусгагдсан нөлөөллийн үнэлгээний аргачлалыг ашиглав. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм, эдийн засагт үзүүлэх боломжит нөлөөллийг тодорхойлохдоо магадлан жагсаах арга, давхцуулан зураглах арга зэргийг ашигласан бөгөөд давхцуулан зураглах аргыг математик загварын аргатай хам байдлаар ашиглан шууд болон шууд бус нөлөөлөлд өртөх байгалийн хам бүрдлийг тодорхойлов.

3.1 Болзошгүй нөлөөллийн үнэлгээ

“И ЭЙЧ ЭС ЭМ” ХХК нь 2020 онд “М-Би-Си Азия Пасифик” ХХК - ийн шар айргийн үйлдвэрийн төслийн баримт бичиг, зураг төсөл, бүртгэл тэмдэглэл, үйлдвэрийн орчинд хийсэн хэмжилтийн үр дүн, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол доройтлын түвшин, химийн бодисын эрсдлийн үнэлгээ зэрэгт үндэслэн үйлдвэрийг 4 хэсэгт хуваан, хэсэг тус бүрт үнэлгээ хийснийг энэ бүлэгт нэгтгэн магадлан жагсаах буюу хяналтын болон асуулгын хуудасны арга, математик статистикийн аргуудыг ашиглан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлсон.

		Хэлбэр		Хугацаа			Чиглэл		Эрчим		
		Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино	Урт	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд	Сул
1. Байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны чанарын асуудал											
1	Орон нутгийн физик өөрчлөлт гарах	Х				Х		Х			Х
2	Усны нөөц ашиглах	-				-		-			-
3	Усны нөөц хомсдох	Х				-		-			-
4	Байгалийн дагалдах нөөц хомсдох	Х				Х		Х			Х
5	Химийн бодис материал ашиглах, хадгалах, тээвэрлэх	-				-		-			-
6	Хатуу хаягдал үүсэх	-				-		-			-
7	Шингэн хаягдал үүсэх	-				-		-			-
8	Агаарт бохирдуулагч бодис ялгарах	-				-		-			-
9	Дуу чимээ, доргио үүсэх	-				-		-			-
10	Ус бохирдуулах	-				-		-			-

11	Осол авар эрсдэл үүсэх	-			-			-			-
2. Эдийн засаг, нийгмийн асуудал											
14	Нийгэм, эдийн засагт эерэгээр нөлөөлөх /бүтээгдэхүүн үйлдвэрлэл өсөх/	+				+		+			+
18	Нийгмийн хариуцлага, соёлд нөлөөлөх	+				+		+			+
19	Ажлын байр нэмэгдэх	+				+		+			+
3. Бусад нөлөөлөл											
21	Хүчтэй салхи, түймэр, аюул осол		-			-		-			-
Дүн, тоогоор		21	-	-	-						
Дүн, хувиар		100	-	-	-						

Хүснэгт 2. Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

(+) Эерэг нөлөөтэй, (-) Сөрөг нөлөөтэй, (х) Ямар нэг эерэг, сөрөг нөлөөгүй

3.2 Нөлөөллийн үр дүн:

Төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол нөлөөллүүдийн хувьд шууд байдлаар сөргөөр нөлөөлөх 9, шууд байдлаар эерэг нөлөөлөх 6 нөлөөлөл байна. Нөлөөллийн хугацааны хувьд 73 хувь нь урт хугацааны, 27 хувь нь богино хугацааны, буцалтгүй нөлөөлөл нийт нөлөөллийн 60 хувь, буцаж нөлөөлөх эерэг нөлөөллүүд 40 хувийг тус тус эзэлж байна.

Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн хувьд “М-Би-Си Азия Пасифик” ХХК болон түүний толгой компани болох “АПУ” ХК нь жилд ойролцоогоор Монгол улсын нэгдсэн төсвийн орлогын 1.6% буюу 129 тэрбум.төг, Онцгой албан татварын орлого 18.3% буюу 95 тэрбум.төг, НӨАТ орлого 1.3% буюу 20тэрбум.төг, Гаалийн татварт 3.7 тэрбум.төг, ААНОАТ-т 4.8 тэрбум.төг, бусад татварт 4.9 тэрбум төгрөгийг дангаараа бүрдүүлдэг тул дунд эрчимтэйгээр урт хугацаанд шууд хэлбэрээр эерэгээр буцаж нөлөөлнө.

Харин орон нутагт физик өөрчлөлт гарах, усны нөөц хомсдох, байгалийн дагалдах нөөц баялаг хомсдох, орчны агаарын чанар зэрэгт ямар нэгэн эерэг, сөрөг нөлөө үзүүлэхгүй

			Түүхий эд бэлтгэх хэсэг	Шүүс бэлтгэх хэсэг	Исгэх хэсэг	Шүүх хэсэг	Савлах хэсэг	Бэлэн бүтээгдэхүүний агуулах	Химийн бодисийн агуулах	Хог хаягдлын цэг	Лаборатори
			A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	A9
Агаар	Агаарт бохирдуулагч бодис ялгаруулах	B1	10	10	6	9	10	10	5	6	5
	Дуу чимээ, доргио чичиргээ үүсгэх	B2	6	8	8	8	4	5	10	10	10
	Агаарт үнэрийн бохирдол үүсгэх	B3	9	9	5	6	9	9	10	10	10
	Цахилгаан соронзон цацраг үүсгэх	B4	10	10	10	10	10	10	10	10	10
Ус	Усны нөөц ашиглах	B5	9	8	9	9	9	10	10	10	8
	Усны нөөцийн хомсдол үүсгэх	B6	9	9	8	9	10	10	10	10	10
	Усны бохирдол үүсгэх	B7	10	8	8	7	10	10	10	10	10
Хөрс	Хөрсөн бүрхэвч эвдрэх	B8	10	10	10	10	10	10	10	8	10
	Хөрс бохирдуулах	B9	10	10	10	10	10	10	10	8	10
	Хөрс доройтох, цөлжих	B10	10	10	10	10	10	10	10	10	10
Ургамал	Ургамлан нөмрөг, ой мод өртөх	B11	10	10	10	10	10	10	10	9	10
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх	B12	9	9	10	10	10	10	10	10	10
Амьтан	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах	B13	10	10	10	10	10	10	10	10	10
	Ховор, нэн ховор амьтан өртөх	B14	10	10	10	10	10	10	10	10	10
Дүн			136	132	124	128	132	134	130	129	130

	Сөрөг нөлөөгүй 9-10	Хамгийн их анхаарал татаж буй асуудлууд: Дуу чимээ Усны бохирдол Усны нөөц ашиглах
	Сөрөг нөлөө бага 7-8	
	Сөрөг нөлөө дунд 5-6	
	Сөрөг нөлөө их 3-4	
	Сөрөг нөлөө маш их 1-2	

Хүснэгт 3. Нөлөөллийн үнэлгээний матриц

Үр дүн: Байесын шалгуураар үнэлсэн нөлөөллийн матрицын үр дүнг нөлөөллийн хүчин зүйлсээр дараалуулбал $A4 > A3 > A2 > A1 > A9 > A5 > A8 > A7$ гэсэн дарааллаар үнэлгээний жин эзэлж байна. Эндээс харахад хамгийн их анхаарал татаж буй асуудлууд болох үүсэх хатуу хог хаягдлын хэмжээ, ашиглаж байгаа цэвэр усны хэмжээ, хаягдал усны чанар, дуу чимээний үзүүлэлтүүдээр хамгийн бага оноо авч байгаа үйлдвэрийн хэсгүүдэд лонх угаах, савлах, архи-пивоны үйлдвэрүүд орж байна. Харин лаборатори болон аюултай хог хаягдлын цэг зэрэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд болзошгүй эрсдэлийн эх үүсвэр болох боловч экосистемд нийтэд нь нөлөөлөх байдал бага байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

Зорилго. “М Би Си Азия Пасифик” ХХК-ий шар айрагны үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлэхүйц, бодитой төлөвлөхөд байгаль орчны менежментийг төлөвлөгөөний гол зорилго оршино.

Гол зорилтууд:



-Байгаль орчны нөлөөллийн нарийвчласан үнэлгээний хүрээнд төлөвлөгдсөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цаашид хийхээр төлөвлөж буй ажлуудыг хариуцах эзэн, зарцуулах зардлын хамт бодитойгоор төлөвлөх

-Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг

бууруулахад хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх

-Агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөл, ажиллагсдын эрүүл мэндэд төслийн үйл ажиллагаанаас хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ хийх арга хэмжээг төлөвлөх

“М Би Си Азия Пасифик” ХХК нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө, химийн бодисын эрсдлийн болон хог хаягдалын менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд сая.төг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах аргазүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг хийгдэх ажлуудын задаргааг хавсралтанд хавсаргав.

2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ МЯН,ТӨГ

№	Ажлын чиглэл	2025 оны зардал/ төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	31,900,000
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	28,700,000
3	Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	34,206,000
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	15,500,000
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,176,000
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
7	Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах төлөвлөгөө	1,200,000
8	БОННУ хийлгэх /И ЭЙЧ ЭС ЭМ/	22,500,000
Нийт		105,282,000

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахдаа төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар дараахи арга хэмжээг авч, хэрэгжүүлнэ.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ АЖЛУУД, ЗАРДАЛ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1. Хөрсөнд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
1.	Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх, зөөгдөх	Нийгмийн хариуцлагын хүрээнд НБОГазартай хамтран Сонгино хайрхан дүүргийн “Инчон мөрөөдлийн төгөлд” шинэс мод тарих.	Тэрбум мод үндэсний төслийг дэмжин ажиллана.	Байгаль орчинд холбогдох төслүүдийг хэрэгжүүлж байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.	300 ширхэг	4,000,000	2025.10	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4, Нийслэлийн засаг даргын 2013 оны А/623 дугаар захирамж
2.	Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх, зөөгдөх	БЗД-ийн нутаг дэвсгэрт мод тарих	Тэрбум мод үндэсний төслийг дэмжин ажиллана.	Байгаль орчинд холбогдох төслүүдийг хэрэгжүүлж байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа хэрэгжүүлнэ	300 ширхэг	4,000,000	2025.10	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4, Нийслэлийн засаг даргын 2013 оны А/623 дугаар захирамж

3.	Үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдал ил задгай үүсэх, хаягдлыг зайлуулалгүй удааснаар хөрс бохирдох	Хог хаягдлын менежментийн талаарх сургалт зохион байгуулах, хог хаягдалын ангилан ялгалтыг нэмэгдүүлэх	Төслийн хүрээнд	Ажилчдад сургалт орох, аян өрнүүлэх	-	3,500,000	Жилийн турш	Хог хаягдлыг ангилан ялгаж хаях тухай журам, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
4.	Үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдал ил задгай үүсэх, хаягдлыг зайлуулалгүй удааснаар хөрс бохирдох	-Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай хатуу хог хаягдал шилжүүлэх устган зайлуулах гэрээ байгуулах, сунган ажиллах - хатуу хог хаягдлыг ангилан ялгах боломжтой шаардлага хангасан хогийн төв цэгийг сайжруулах - хог хаягдлыг тогтмол хугацаанд шилжүүлэх	Төслийн хүрээнд	Хог хаягдлын гэрээ сунгуулсан, хог хаягдлын цэгийг сайжруулсан байх	-	10,000,000	Жилийн турш	Хог хаягдлын тухай хууль 9.2.2. 9.4.8, Эрүүл ахуйн тухай хууль MNS 5344:2003 Хог хаягдлыг ангилан ялгаж хаях тухай журам, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
5.	Химийн бодис асгарч, хөрс бохирдох	Химийн бодисын үлдэгдэл бүхий сав, баглаа, боодлийг ил задгай хаяхгүй байх, агуулах савны битүүмжид байнга хяналт тавьж ажиллах	Төслийн хүрээнд	Химийн бодисын агуулахад хадгалах химийн хаягдалын бүртгэл хөтөлсөн байна.	Химийн бодисын бүртгэл тайлан	Үйл ажиллагааны зардлаар	Жилийн турш	Монгол Улсын хууль 2006/5/25 Химийн хортой болон аюултай бодисын тухай хуулийн 2р бүлэг 8,1 заалт
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								

6.	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс шалтгаалж агаарт тоосжилт үүсэх	Орчны тоосжих нөхцлийг бууруулах үүднээс дулааны улиралд үйлдвэр, уурын зуух, авто граж болон агуулахын орчинд чийгтэй цэвэрлэгээ болон үртсэн цэвэрлэгээ тогтмол байнга хийх	Төслийн хүрээнд	Тоосжилт агаар орчны шинжилгээний дүн хэвийн байх	-	Үйл ажиллагааны зардлаар	Жилийн турш	Агаарын тухай хууль - Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль MNS 4585:2007 -Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5885:2008 - Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага"
7.	Нүүрсхүчлийн хий, хөргөлтийн бодис, шингэрүүлсэн хийн түлш агаарт алдагдах	Үйлдвэрлэлийн бүсэд суурилуулсан CO2 хэмжигч багаж тогтмол хянах эсэх ОХШХ-ийн дагуу жилд нэг удаа тогтоогдсон цэгүүд дээр агаарын шинжилгээ хийлгэдэг эсэх	Төслийн хүрээнд	CO2 хэмжигчийн хяналт шалгалт, орчны хяналт шинжилгээний дүн хэвийн байх	1	1.300.000	Жилдээ 1 удаа	
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
3. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө								
8.	Үйлдвэрлэл үйл ажилагаанд ус их хэмжээгээр хэрэглэснээс усны нөөц хомсдох	Дэлхийн усны өдөрлөг зохион байгуулах, сургалт орох	Төслийн хүрээнд	1,500,000			I улиралд	-
9.	Ус хяналтгүй алдагдаж усны нөөцөд нөлөөлөх	Үйлдвэрийн болон ахуйн ус дамжуулах шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтад тогтмол хяналт тавьж, гэмтсэн тохиолдолд засах арга хэмжээ авч ажиллах	Төслийн хүрээнд	Усны ерөнхий тоолууруудыг баталгаажуулалт хийлгэсэн тоо	3	600,000	Жилийн турш	Усны ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам БОНХЯ-ны сайд, 2014/01/06, MNS0900:2018.

10	Усны бохирдол үүсэхээс сэргийлэх	Дэлхийн Байгаль орчны өдөрлөг зохион байгуулах	Төслийн хүрээнд	Нийгмийн хариуц-лагын хүрээнд цэвэрлэгээ хийх	1	2,000,000	Жилийн турш	Усны тухай хууль болон холбогдох дүрэм журам
11	Төслийн хүрээнд усны нөөц ашиглах, хомсдох	Үйлдвэрийн цех бүрийн усны хэрэглээг нарийвчлан тооцох, нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны нормыг хамгийн боломжит бага хэмжээнд байлгах -Усны нөөцийг хэмнэх, дахин ашигласан усны хэмжээ, хэрэглээг нэмэгдүүлэх	Төслийн хүрээнд	Ус дахин ашиглах болон, хэмнэлт хийх багууд ажиллуулах	-	Сайжруулалтын багуудын нэмэлт урамшуулал	Жилийн турш	Усны тухай хууль болон холбогдох дүрэм журам, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 20.1.3
12	Төслийн хүрээнд усны ашиглалт зарцуулалт	Ус ашиглалтын төлбөрийг гэрээний дагуу тооцож, тогтоосон хугацаанд нь төлөх	Төслийн хүрээнд	Ашигласан усны хэмжээнээс хамаарч тооцно			Үйл ажиллагааны туршид	Усны тухай хууль болон холбогдох дүрэм журам
	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	№
4. Ажилчдын эрүүл мэнд								
13	Ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй	Ажиллагсдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Үйлдвэрийн ажиллагсад	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулна.		5,200,000	I IV улирал	Монгол улсын эрүүл мэндийн сайдын 2017/4/14 өдрийн А/145 дугаар тушаал
14.	Ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй	Ажилчдын эрүүл мэндийн даатгалд хамруулах.	Үйлдвэрийн ажилчдад	Эрүүл мэндийн даатгалд хамруулах		Boostbie төслийн хүрээнд	Жилд 1 удаа	
Нийт төсөв							31,900,000	


6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Нийт зардал мян. Төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Үйлдвэрийн гарц хэсгийн явган хүний замыг тохижуулах	Тэмдэг тэмдэглэгээ хийх	Үйлдвэрийн орох, гарах хэсгийн зам	Тэмдэг тэмдэглэгээ хийх	5,700,000	2025.5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай
2.	Хог хаягдлын цэгийг шинээр төлөвлөх	Эмхлэх цэгцлэх, цэвэрлэгээ, ангилалт, стандартжуулалт, Хог хаягдлын хэмжээг багасгах	Үйлдвэрийн хог хаягдлын төвлөрсөн цэг	Хог Хаягдлын цэг эмх цэгцтэй байх, хэмжээг багасгах	13,000,000	2025.8 сар	Монгол улсын хууль, хог хаягдлын тухай хууль 2017/05/12
3.	Эзэмшил талбайн ногоон байгууламжийн арчилгаа хийх	Зүлэгжүүлэлтийг услах, тогтмол сэргээх.	Үйлдвэрийн ногоон байгууламж	Эзэмшлийн талбайн зүлэг, мод бут ургалт сайн тохижилт хийгдсэн байна.	10,000,000	Жилийн турш	Хөрс хамгаалах цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4, Нийслэлийн засаг даргын 2013 оны А/623 дугаар захирамж
4	Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцах	Компанийн эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Нийтийн эзэмшлийн зам талбайд	-	2025	Нийгмийн хариуцлагын хүрээнд
Нийт зардал						28,700,000	

7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Түүх соёлын дурсгалт зүйлс

Төслийн талбайн ойр орчим түүх, соёлын дурсгалт ач холбогдолтой ямар нэгэн зүйл байхгүй болно. Гэвч төслийн үйл ажиллагааны явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт, зүйл олдох аваас холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны нэгж болон холбогдох байгууллага болох ШУА-ын Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж, төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох шаардлагатай.



№	Y	X
1	5309857,12	651103,39
2	5310023,22	651177,48
3	5309931,70	651383,73
4	5309921,38	651387,92
5	5309923,90	651434,08
6	5309903,56	651426,14
7	5309747,97	651362,51
8	5309760,61	651331,41
9	5309775,78	651295,98
10	5309785,87	651271,87
11	5309795,70	651248,64
12	5309810,86	651212,82
13	5309817,12	651198,30

Зураг 11. Компанийн байршил

Тусгай зөвшөөрөл бүхий талбайн өнцгүүдийн газар зүйн солбицлууд

8.ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд 96 гаруй төрлийн химийн бодис, урвалж, бүтээгдэхүүнийг зөвшөөрлийн дагуу ашигладаг.

Тээвэрлэлтийн үед үүсч болзошгүй эрсдэл:

- Тээвэрлэлтийн явцад химийн бодисыг тээвэрлэх журам, аюулгүй ажиллагааг баримтлаагүйн улмаас бодис асгарч алдагдах, хөрс, ус бохирдуулах, жолооч, ачигч, ажиллагсдыг хордуулах, галын аюул, осол зэрэг эрсдэл үүсч болзошгүй юм.
- Химийн бодисуудыг ачиж буулгах үед бодис асгарч, алдагдаж байгаль орчныг бохирдуулах, жолооч ажиллагсад хордох эрсдэл үүсч болзошгүй.
- Тээвэрлэлтийн явцад бодисын сав, баглаа боодлын бүрэн бүтэн биш байдлаас үүдэн химийн бодис асгарч алдагдсанаар байгаль орчин бохирдох, галын аюул, осол үүсч болзошгүй.
- Тээврийн хэрэгслийн эвдрэл, гэмтэл мөн жолооч, ачигчдын болгоомжгүй үйлдлийн улмаас бодис асгарах, галын аюул, осол үүсч болзошгүй.

Хадгалалтын үед үүсч болзошгүй эрсдэл:

- Хадгалалтын явцад химийн бодисыг хадгалах журам, хор аюулын мэдээлэлд заасан зааврыг мөрдөөгүйн улмаас бодис асгарах, бодисын шинж чанар муудах, байгаль орчин, ажлын байр бохирдож болзошгүй.
- Химийн бодисын сав, баглаа боодлыг задлан ил задгай, хяналтгүй хадгалсаны улмаас бодисын тоос агаарт тархах, бодис асгарах, мөн бодисын шинж чанар өөрчлөгдөх, байгаль орчинд бохирдол үүсгэх зэрэг эрсдэл үүсч болзошгүй.
- Химийн бодис хадгалж буй агуулахын цонх, битүүмжлэл бүрэн бүтэн байдал алдагдсаны улмаас бодисын хадгалалтын горим алдагдах, осол аюул үүсч болзошгүй.
- Ажиллагсад бодистой ажиллах үед аюулгүй ажиллагаа, хувцас хэрэгсэлгүйн улмаас арьс салст, нүд амьсгалын замаар хүрэлцэх, хордох зэргээр эрсдэлд өртөж болзошгүй.
- Бодисын хяналтгүй асгаралт, алдагдлын улмаас агаарт хорт хий ялгарах, хүн ам, эд хөрөнгө, тоног төхөөрөмж эвдэрч сүйдэх зэргээр осол аюул үүсч болзошгүй.

Ашиглах явцад үүсч болзошгүй эрсдэл:

- Химийн бодисуудыг задлах, уусмал бэлтгэх, савлах зэргээр химийн бодистой ажиллах явцад бодис асгарах, уурших зэргээр ажиллагсдыг хордуулж болзошгүй.
- Санамсаргүй ослын улмаас химийн бодис асгарах, алдагдах тухайн орчныг бохирдуулах, ил гал, дөлний улмаас галын аюул үүсч болзошгүй.
- Ажиллагсад бодистой ажиллах үед аюулгүй ажиллагаа, хувцас хэрэгсэлгүйн улмаас арьс салст, нүд, амьсгалын замаар хүрэлцэх, хордох зэргээр эрсдэлд өртөж болзошгүй.
- Бодисын хяналтгүй асгаралт, алдагдалын улмаас хөрс, усан орчин, бохирдох мөн болзошгүй галын аюулын улмаас агаарт хорт хий ялгарах, хүн ам, эд хөрөнгө, тоног төхөөрөмж эвдэрч сүйдэх зэргээр осол аюул үүсч болзошгүй.

ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЖЛУУД, ЗАРДАЛ

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Аюултай бодис асгарах	Химийн бодисыг тухайн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулах	Үйлдвэр, Лаборатори, Уурын зуух, Химийн бодисын агуулах гэх мэт Үйлдвэрийн төслийн талбайн шаардлагатай газруудад	Асгаралтын иж бүрдэл 5ш	5,280,000	Жилийн турш	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
2.	Химийн бодисын эрсдэл	Химийн бодисын сургалт	Үйлдвэрийн хэмжээнд гадаад болон дотоод сургалт	-	1,300,000		Монгол Улсын хөдөлмөрын сайдын 2016 оны А/33-р тушаал
3.	Гал түймэр	Үйлдвэрийн төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах боломжтой бүх арга хэмжээг авах галын гидрант, галын сараа, хайрцаг	Барилга байгууламж, Алба нэгжүүдэд.	Шаардлагатай газруудад шинээр байрлуулах болон цэнэглэх	14,500,000	Жилийн турш	Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/, 3 дугаар бүлэг Гамшгаас хамгаалах тухай хууль, 5 дугаар бүлэг
4.	Галын аюулгүй байдлын сургалт, болон гамшгийн сургалт	Онцгой байдлын газар болон, гамшгийн эрсдлийн төвтэй хамтарсан сургалт.	Үйлдвэрийн ажилчдад	-	1,700,000	III улиралд	Галын аюулгүй байдлын тухай хууль

5.	Хадгалалтын үед үүсч болзошгүй эрсдэл	Агуулахын гадна болон дотор химийн бодисын хор аюулыг анхааруулсан тэмдэг тэмдэглэгээг байршуулах, агуулахын орчим ил гал гаргах, тамхи татахгүй байх	Шаардлагатай алба нэгжүүдэд	Шаардлагатай газруудад шинээр байрлуулах болон цэнэглэх	1,500,000	Жилийн турш	Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаал
6.	Хадгалалтын үед үүсч болзошгүй эрсдэл	Ажиллагсдыг химийн бодистой ажиллах хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр бүрэн хангах, хэрэглэж хэвшүүлэх	Шаардлагатай алба нэгжүүдэд	Тухайн жилийн төсөвдөө оруулах	6,00,000	Жилийн турш	Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаал
7.	Ашиглах явцад үүсч болзошгүй эрсдэл	Химийн бодисуудын болон аюултай хог хаягдлын агуулахад химийн бодисуудын сав баглаа боодлыг хадгалахдаа эмх цэгцтэй, хаяг шошгожуулсан байх, MSDS шинэчлэх	Шаардлагатай алба нэгжүүдэд	-	Үйл ажиллагааны зардлаар	Жилийн турш	Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаал
8.	Ашиглах явцад үүсч болзошгүй эрсдэл	Нүд, арьс салст, амьсгал болон залгисан тохиолдолд зааврын дагуу арга хэмжээ авах, эмнэлгийн тусламж үзүүлэх	Үйлдвэр, Лаборатори, Уурын зуух, Химийн бодисын агуулах гэх мэт Үйлдвэрийн төслийн талбайн шаардлагатай газруудад ажилладаг ажилчдад	Шаардлагатай газруудад шинээр байрлуулах болон цэнэглэх	3,926,000	Жилийн турш	Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаал
Нийт зардал							34,206,000

9.ХОГ ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах үүднээс ахуйн болон үйлдвэрийн гаралтай хатуу, шингэн, хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө багатайгаар хэрхэн цуглуулж, ангилан, дахин ашиглах, зайлуулах арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэхэд энэхүү төлөвлөгөөний зорилго оршино. Тухайлбал аюултай болон химийн хорт бодисын сав баглаа боодол болон хаягдал шилийг дахин боловсруулах үйлдвэрүүдэд тус тус нийлүүлдэг боллоо. Үйлдвэрлэлээс гарч буй органик түүхий эд болох улаан буудай, арвайн соёолжийн үлдэгдлийг малчдад нийлүүлэн өгч байна. 2025 онд хог хаягдлын 3R менежментийг хэрэгжүүлэн ангилан хаялтыг нэмэгдүүлэн дахивар хаягдлуудыг дахин ашиглаж, дахин боловсруулалтанд шилжүүлэн ландфиллд хаягдах хог хаягдлын хэмжээг бууруулахаар зорин ажиллана.



ШИЛ ТАТАН АВАЛТ



АПУ компани нь нийт 18 аймгийн 650-700 харилцагчдаас лонхоо эргүүлэн татаж байна.

- АПУ компани нь нийт 18 аймгаас 650-700 харилцагчдаас лонхоо эргүүлэн татаж байна.
 - Гадаад:
 - Гуравдагч бэлтгэн нийлүүлэгч
 - Дотоод:
 - Борлуулалтын сувгууд
 - Бөөний төв
 - Эргэтийн сав, баглаа боодлын менежментийн алба
 - Оффис, үйлдвэрийн бүсийн лонх авах цэг
- Үүнээс М Би Си Азия Пасифик ХХК Нийт 5 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд шилэн савалгаатай гардаг Сэнгүр болон , Super Lite шар айрагны шилийг эргүүлэн татаж байна.



2024 онд
Сэнгүр 78%
Tiger 100% эргүүлэн татан авсан.

2025
онд 88%-г татан авах зорилготой ажиллаж байна.

ХОГ ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ АЖЛУУД, ЗАРДАЛ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	Дахин ашиглах боломжгүй устгах хог хаягдлыг гэрээний дагуу хог хаягдлын компанид шилжүүлэх	Төслийн хүрээнд, “ЭКО ОРЧИН” ХХК	Тн, ангилан ялгах боломжгүй ахуйн хог хаягдал	-	Гэрээний дагуу	Жилийн турш	Монгол улсын хууль, хог хаягдлын тухай хууль 2017/05/12
2.	Дахин боловсруулах, хог хаягдал	Хаягдал гялгар рулоныг Мультифак ХХК үнэгүй нийлүүлэн буцааж багцлагч халь болгон үйлдвэрийн хэрэглээнд худалдан авах	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Тн, дахин ашиглах хог хаягдлын хэмжээ	20тонн	Гэрээний дагуу	Жилийн турш	Монгол улсын хууль, хог хаягдлын тухай хууль 2017/05/12
3.	Аюултай	“Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах” хэрэгжилтийг хангаж ажиллах	Төслийн хүрээнд	Тн,	Улирал д 1 удаа	12,00,000	Жилийн турш	Монгол улсын хууль, хог хаягдлын тухай хууль 2017/05/12
4.	Шингэн хаягдал	Төслөөс гарч байгаа шингэн хог хаягдлыг УСУГ хийсэн гэрээний дагуу шилжүүлэх	Төслийн хүрээнд	м3	-	Нийлүүлсэн хэмжээгээр	Сар тутам	Монгол улсын хууль, хог хаягдлын тухай хууль 2017/05/12
5	Хог хаягдлын хэмжээг тооцоолох	Төслөөс гарч байгаа нийт хог хаягдлын хэмжээг тооцоолох, Application-тай болох	Төслийн хүрээнд	-	-	Үйл ажиллагааны зардлаар	-	

6	Хог хаягдалын ангиан ялгах дадал суулгах	Нийт ажилчдад гадны болон, дотоод сургалт мэдээллээр хангах	Үйлдвэрийн ажилчдад	-	тогтмол	3,500,000		Монгол улсын хууль, хог хаягдлын тухай хууль 2017/05/12
Нийт зардал							15,500,000	

10. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР АЖЛУУД, ЗАРДАЛ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1.	Хөрсний чанар- Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	1.Авто зогсоол, 2.Гадаа талбай, 3.Хогийн цэг	Жилд 1 удаа	1	500,000	500,000	Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2.	Хөрсний чанар - Хүнд металлууд	1.Авто зогсоол, 2.Уурын зуух, 3.Хогийн цэг	Жилд 1 удаа	1	1,000,000	1,000,000		
3.	Агаарын чанар – Тоос (PM2.5 ба PM10), орчны агаар дахь зарим хийнүүд (SO2, NO2, CO)	Уурын зуухны ард	Жилд 1 удаа	1	1.100.000	1.100.000	“Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори.	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ажлын байрны орчин зөвшөөрөгдөх дээд хэмжээ
5.	Цэвэр усны шинжилгээ, бичил амь судлалын үзүүлэлт, нийт бичил биетэн ба гэдэсний бүлгийн нийт нянгийн тоо, өвчин үүсгэгч нян pH	Цэвэр усны шугам плантын өрөө	1 жилд	2	96000	192,000	УСУГ -ын төв лабораторид жилд шинжлүүлнэ	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ, MNS (ISO) 10523:2001 Усны чанар pH тодорхойлох
6.	Хаягдал бохир усны хими болон физикийн үзүүлэлт, pH, умбуур бодис, хүнд металлын агууламж, COD	Үйлдвэрийн хаягдал ус цуглуулах танк	Улиралд 1 удаа	4	96000	384,000	УСУГ -ын төв лабораторид жилд шинжлүүлнэ	MNS6561:2015 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усанд тавигдах ерөнхий шаардлага
Нийт зардал							3,176,000	

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЖЛУУД, ЗАРДАЛ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар 1-3	Сар 4-6	Сар 7-9		
1.	Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллаж, гамшгийн бэлэн байдал болон гэнэтийн осол, эрсдэлийн талаар сургалт зохион байгуулах	-		x		ХАБЭА инженер	Ажилчдыг гэнэтийн ослын үед цаг алдалгүй арга хэмжээ авах мэдлэгтэй болгох ба гэрээг тогтмол сунгаж ажиллана.
2.	Жил бүрийн гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.	-			x	Байгаль орчин, эрүүл ахуй ажилтан	Байгаль орчны хамгаалах тухай хууль
3.	Хог хаягдалын гэрээг сунгуулах	-	x			Байгаль орчин, эрүүл ахуй хариуцсан ажилтан	
4.	Нийгмийн хариуцлагын хүрээнд: Байгаль орчинд ээлдээ арга хэмжээг төрийн болон хувийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Гэрээний дүн			x	ХАБЭА инженер Байгаль орчин, эрүүл ахуйн хариуцсан ажилтан	Байгаль орчинд холбогдох төслүүдийг хэрэгжүүлж байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.
5.	Энгийн болон аюултай хог хаягдалаас үүсэх сөрөг нөлөөлөлийг бууруулах боломжит арга технологийг судлах	-	x			ХАБЭА инженер Байгаль орчин, эрүүл ахуйн ажилтан	Хог хаягдалын хэмжээ болон түүнд зарцуулах зардал багасна.
6.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Мод тарих аян, их цэвэрлэгээ гэх мэт бусад аян үйл ажиллагаа зохион байгуулах	Гэрээний дүн	x		x	ХАБЭА инженер, Байгаль орчин, эрүүл ахуйн ажилтан	Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах

7.	Эрчим хүчний менежмент: Дулаан цахилгааны алдагдлыг бууруулж, хэмнэлтийн баг үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, шийдлээр хэрэглээг багасган ажиллах	Дотоод үйл ажиллагааны зардал	х	х	х	ХАБЭА инженер, Цахилгаан автоматик инженер, Байгаль орчин, эрүүл ахуйн ажилтан	Нэгж үйлдвэрлэлд зарцуулах хэрэглээг бууруулна.
8.	Усны алдагдлыг бууруулж, хэмнэлтийн баг үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, шийдлээр хэрэглээг багасган ажиллах	Дотоод үйл ажиллагааны зардал	х	х	х	ХАБЭА инженер, Ашиглалт инженер, Байгаль орчин, эрүүл ахуйн ажилтан	MNS0900:2005 Хүрээлэн буй орчин, Ундны усны эрүүл ахуйн шаардлага
9.	БОННУ хийлгэх /И ЭЙЧ ЭС ЭМ/	22,500,000	х	х	х	ХАБЭА инженер, Байгаль орчин, эрүүл ахуйн ажилтан	Байгаль орчны тухай хуулийн нийцлийг хангуулах, үнэлгээ хийлгэх
Нийт төсөв		22,500,000					

12. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээлэлийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилго юм.

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА БОЛОН ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ЗАРДАЛ

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1.	Хорооны иргэдийн төлөөлөл	Тайлагнах, хэлэлцүүлэх	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил	Жил бүрийн 10 сард	1,200,000	Байгаль орчин, эрүүл ахуй хариуцсан ажилтан	Компанийн байранд
2.	Нийслэлийн байгаль орчны газар	Тайлагнах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах талаар хийгдсэн ажил, БОМТ-ний тайлан	Жил бүрийн 11 сард	Дотоод үйл ажиллагааны зардал	Байгаль орчин, эрүүл ахуй хариуцсан ажилтан	Нийслэлийн байгаль орчны газар
3.	БОАЖЯ Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газар	БОМТ-ний тайлан, төлөвлөгөөг батлуулах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ авах, хяналт шинжилгээний дагуу хийсэн ажлыг	Жил бүрийн 12 сар	Дотоод үйл ажиллагааны зардал	ХАБЭА инженер	БОАЖЯ Eis.mn гео мэдээллийн санд тухайн жилийн биелэлтийн тайлан болон дараа жилийн төлөвлөгөөг оруулах
Нийт зардал						1,200,000	


ДҮГНЭЛТ

“М Би Си Азия Пасифик” ХХК буюу хүмүүсийн сайн мэддэгээр Тайгер шар айрагны үйлдвэр нь хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO22000, Чанарын менежментийн тогтолцоо ISO9001:2015 стандартуудыг хэрэгжүүлэн хэрэглэгчдийн таашаалд нийцсэн шар айраг үйлдвэрлэх явцдаа үйлдвэрээс байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөлд тогтмол анхаарал хандуулж, байгаль орчны менежментийн тогтолцоог хэрэгжүүлэн, чанар, бүтээмж, менежментээ ямагт сайжруулан ажиллаж байна.

Компанийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бид дараах байдлаар дүгнэлээ.

- Манай компани байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор нүүрсээр ажилладаг DZL4-1.25-All зуухнуудыг шингэрүүлсэн нефтийн хий (LPG) болон дизель түлшээр ажилладаг зуухаар сольж, уурын зуухны төслөө амжилттай хэрэгжүүлэн агаарын бохирдол үүсгэхгүй байгальд ээлтэй компани болсон.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар 2021-2030 он хүртэл хэрэгжиж байгаа “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд манай компани 2021 оноос эхлэн нэгдсэн бөгөөд 2024 онд 500 ширхэг модыг “Нүри” ХХК-тай хамтран тарьлаа. Цаашид энэ тоог нэмэгдүүлэхээр зорин ажиллаж байна.
- Бид Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл мэндийн төвөөс “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ”-ний талаар ирүүлсэн зөвлөмжүүдийг сайжруулах ажлын хүрээнд ажилчдаа нарийн мэргэжлийн эмчийн үзлэг шинжилгээнд хамруулсан.
- Хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан бий болсон хог хаягдлыг багасгахад ард иргэдийг уриалах зорилгоор “Хатан Туул” аяныг бид амжилттай зохион байгуулж, уламжлал болгох зорилгыг тавьж ажилласан.
- Дэлхийн Байгаль орчны өдрүүдийг тохиолдуулан хүрээлэн буй орчныг сайжруулахад иргэн бүрийн оролцоо чухал уриан дор 3 өдрийн өдөрлөг зохион байгуулсан бөгөөд цаашид тогтмол зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.
- Манай компани нь 2025 онд Баянзүрх дүүргийн Тохижилт үйлчилгээний газар болон Эко орчин ХХК, Мультифак ХХК, Түмэн эгшиг ХХК зэрэг аж ахуй нэгжтэй хог хаягдлын гэрээ байгуулан, хамтран ажиллаж байгаа бөгөөд үйлдвэрээс гарсан нийт хог хаягдлын 85 хувийг энэхүү компаниудаар дамжуулан дахин боловсруулж байна.
- Байгалийн нөөцийн хэмнэлтийн зорилгын хүрээнд дулаан цахилгаан эрчим хүч усны хэрэглээгээ өмнөх оны энэ үетэй харьцуулахад бууруулан ажиллаа.
 - Мөн 2024 онд Байгаль орчны тухай хуулийн 10.1 заасны дагуу “Green service” компаниар Байгаль орчны аудит хийлгэж **96,1** хувьтай үнэлэгдсэн .
 - цаашид “М БиСи Азия Пасифик” компани нь үйлдвэрлэл үйл ажиллагаагаа тогтвортой явуулахын зэрэгцээ нийгмийн хариуцлагынхаа хүрээнд үйлдвэрээс байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэж байгаль орчны менежментийн тогтолцоог тогтмол хэрэгжүүлэн ажиллана.

ХАВСРАЛТ

		МОНГОЛ УЛС ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ	
20 ²² оны 07 сарын 26 өдөр	Дугаар 9022/075	Улаанбаатар хот	
Эрхлэх үйл ажиллагааны төрөл		Шар айраг үйлдвэрлэх	
Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр		"М Би Си Азия Пасифик" ХХК /РД:5027292/	
Хаяг		Улаанбаатар, Баянзүрх, 10-р хороо, Амгалан /13260/ Гачууртын зам-102/1	
Тусгай зөвшөөрлийн хугацаа		2022.07.31 – 2025.07.31 хүртэл	
Тавих нөхцөл, шаардлага		Стандартын шаардлага	
		хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх,	
		Тусгай зөвшөөрлийг хугацаанд нь сунгуулах	
		Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах	
Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 20 ²² оны 07 сарын 22 өдрийн А/239 дугаар тушаалыг үндэслэн олгов.			
САЙД		 З.МЭНДСАЙХАН	



МОНГОЛ УЛС

АЖ АХУЙН НЭГЖИЙН ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН

ГЭРЧИЛГЭЭ

Дугаар: 0000300484

М Би Си азиа пасифик ХХК	5027292		
(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)	(регистрийн дугаар)		
Нийслэлийн Засаг даргын захирамж 20 24 оны 06 сарын 26 өдрийн А/779 тоот			
(шийдвэр гаргагч)			
шийдвэрийг үндэслэн	Улаанбаатар	Баянзүрх	10-р хороо
	(аймаг, нийслэл)	(сум, дүүрэг)	(баг, хороо)
Гачууртын зам	102, 102/1, 102/2, 102/3, 102/4, 102/5, 102/6, 102/7 хаягт		
	(гудамжны нэр)	(хашааны дугаар)	
байрлах, нэгж талбарын	1331502419	дугаар бүхий	40558 м.кв газрыг
Үйлдвэрлэлийн барилга, байгууламж, бусад газар			зориулалтаар
